

**САНГИЙН САЙДЫН ДЭРГЭДЭХ НЯГТЛАН ҂ОДОХ БҮРТГЭЛ,
АУДИТЫН СТАНДАРТЫН ХОРООНЫ ТОГТООЛ**

2023 оны 01 дүгээр
сарын 24-ний өдөр

№15

Улаанбаатар хот

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 21 дүгээр зүйл болон Сангийн сайдын 2016 оны 323 дугаар тушаалыг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. АОУС-ын 2020 оны хэвлэлийн монгол орчуулгыг бүрэн эхээр нь баталсугай.
2. АОУС-ын 2020 оны хэвлэлийн монгол орчуулгыг олон нийтэд хүргэх арга хэмжээг 2023 оны 03 дугаар сард багтаан хэрэгжүүлж, үр дүнг танилцуулахыг ММНБИ /Б.Оюунбаатар/-д үүрэг болгосугай.
3. Хорооны 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.
4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газар /Б.Болормаа/-т үүрэг болгосугай.

САНГИЙН ДЭД САЙД БӨГӨӨД
НЯГТЛАН ҂ОДОХ БҮРТГЭЛ, АУДИТЫН
СТАНДАРТЫН ХОРООНЫ ДАРГА

С.МӨНГӨНЧИМЭГ

БАТЛАВ. САНГИЙН ДЭД САЙД БӨГӨӨД
НЯГЛАН БОДОХ БҮРТГЭЛ, АУДИТЫН
СТАНДАРТЫН ХОРООНЫ ДАРГА

С.МОНГОНЧИМЭГ

**НЯГЛАН БОДОХ БҮРТГЭЛ, АУДИТЫН СТАНДАРТЫН
ХОРООНЫ 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

| № | Хийх ажил | Хамтарч ажиллах байгууллага | Хугацаа | Хариуцах ажилтан |
|----|--|-----------------------------|----------------|-------------------------|
| 1 | НББАСХ-ны 2022 оны тайлан, 2023 оны төлөвлөгөөг боловсруулж, батлах | - | 1 дүгээр сард | Э.Буянхишиг |
| 2 | АОУС-ын 2020 оны хэвлэлийн орчуулгыг хэлэлцэн, батлах (2400 хуудас) | ММНБИ | 1 дүгээр сард | Хорооны гишүүд |
| 3 | НББАСХ-оор батлагдсан стандартуудыг хэвлэх, борлуулах, давтан сургах чиглэлээр ММНБИ-ийн гүйцэтгэж байгаа үйл ажиллагааны тайлан сонсох | ММНБИ | 1 дүгээр сард | ММНБИ Хорооны гишүүд |
| 4 | Үнэлгээний олон улсын стандартын 2022 оны орчуулгыг хэлэлцэн, батлах (130 хуудас) | ММҮИ | 4 дүгээр сард | Хорооны гишүүд |
| 5 | Төрийн болон орон нутгийн өмчит тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгжийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нэгтгэл дүгнэлт, шинжилгээг танилцуулах. | - | 4 дүгээр сард | Э.Буянхишиг |
| 6 | "Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланд шинжилгээ хийх үлгэрчилсэн аргачлал"-ын шинэчлэн боловсруулсан төслийг танилцуулах | - | 4 дүгээр сард | Э.Буянхишиг |
| 7 | СТОУС-ын 2021 оны хэвлэлийн Б хэсэг буюу "Хэрэгжүүлэх заавар, удирдамж"-ийн орчуулгыг хэлэлцэн, батлах (945 хуудас) | ММНБИ | 7 дугаар сард | Хорооны гишүүд |
| 8 | Банк бус санхүүгийн байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн заавар, журмын шинэчлэн боловсруулсан төслийг танилцуулах | Санхүүгийн зохицуулах хороо | 7 дугаар сард | Э.Буянхишиг |
| 9 | Хадгаламж зээлийн хоршоонд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн заавар, журмын шинэчлэн боловсруулсан төслийг танилцуулах | Санхүүгийн зохицуулах хороо | 7 дугаар сард | Э.Буянхишиг |
| 10 | СТОУС-ыг дагаж мөрдөхөд санхүүгийн салбарын хууль, дүрэм, журмын нийцтэй эсэхэд дүн шинжилгээ хийж танилцуулах | - | 7 дугаар сард | Н.Мөнхцацрал |
| 11 | Аудитын хуулийн этгээдэд хийсэн чанарын дунг хэлэлцэх | ММНБИ | 12 дугаар сард | Э.Буянхишиг |
| 12 | Үнэлгээний хуулийн этгээдэд хийх чанарын хяналтын журмын төслийг | ММҮИ | 12 дугаар сард | Э.Буянхишиг |

| | | | | |
|----|--|-------|----------------|----------------------------|
| | танилцуулах | | | |
| 13 | НББАСХ-оор батлагдсан стандартуудыг хэвлэх, борлуулах, давтан сургах чиглэлээр ММНБИ-ийн гүйцэтгэж байгаа үйл ажиллагааны тайлан сонсох | ММНБИ | 12 дугаар сард | ММНБИ Хорооны гишүүд |
| 14 | Хөрөнгийн үнэлгээний үйлчилгээний хөлсний жишиг үнийн төсөл, бизнесийн үнэлгээний, үл хөдлөх болон хөдлөх хөрөнгийн, санхүүгийн тайлагналын үнэлгээний журам, аргачлалын төсөл танилцуулах | ММҮИ | Тухай бүр | Э.Буянхишиг |

-00-